



“КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ТАНАА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2025.11.20 № 6/4237 .

Бүтээгдэхүүнийг цахим хуудсанд
шинэчлэн байршуулсан тухай

“Коннектлайф даатгал” ХХК-аас 2025 оны А-31/2025 дугаар албан бичгээр ирүүлсэн “Ипотекийн зээлдэгчийн амь насны даатгал”-ын бүтээгдэхүүнийг шинэчлэн “Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”, “Ипотекийн зээлдэгчийн гэнэтийн ослоос үүдэлтэй амь нас, эрүүл мэндийн даатгал” гэсэн төрөлтэй болгох тухай мэдээлэл, баримт бичгийг Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн дагуу хүлээн авч танилцлаа.

Тус компанийн “Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын бүтээгдэхүүн нь дээрх хууль, журмын шаардлагыг хангасан байх тул “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 6.1.16-д “Даатгагч нь даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг шинээр болон шинэчлэн зах зээлд борлуулахаас өмнө тухай бүр энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан мэдээллийг Хороонд ирүүлэх ба тус мэдээллийг шинэчлэн Хороо өөрийн цахим хуудсанд байршуулна” гэж заасны дагуу Хорооны цахим хуудсанд шинэчлэн байршуулав.



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1	Мэдэгдэл огноо	Он	2025	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Коннектлайф Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хугацаат амьдралын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо	Дугаар		
		Ипотекийн даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэн батлах тухай		2025.10.15	№ СЕО/О – 21/2025		
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч	Овог		Нэр			
		Батзориг		Даваасүрэн			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	<input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг банк даатгалын зуучлагчаар дамжуулан зуучлан борлуулах						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд					
	Даатгалын үндсэн эрсдэл	Аливаа шалтгааны улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар хугацаагүй алдах.					
		Гэнэтийн ослын улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар хугацаагүй алдах					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	<p>Аливаа шалтгааны улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар хугацаагүй алдах сонголтын хувьд: Даатгалын хураамж нь даатгуулагчийн нас, хүйс, зээлийн хугацаа, зээлийн дүнгийн үлдэгдэлд суурилан тооцогдох бөгөөд 1,000 төгрөгийн хамгаалалт тутамд жилд төлөх хураамж нь 1.64-29.31 төгрөг (0.164% - 2.931%) хооронд гэрээний хугацаа, нас, хүйсээс хамааран өөр байна.</p> <p>Даатгуулагч сар бүрийн хураамжаа зээлийн эргэн төлөлтийн графиктай уялдуулан тэнцүү хэмжээгээр хуваан төлж болно.</p> <p>Гэнэтийн ослын улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар хугацаагүй алдах сонголтын хувьд: Даатгалын хураамж нь даатгуулагчийн нас, хүйс, зээлийн хугацаа, зээлийн дүнгийн үлдэгдэлд суурилан тооцогдох бөгөөд 1,000 төгрөгийн хамгаалалт тутамд жилд төлөх хураамж нь 0.27-2.94 төгрөг (0.027%-0.294%) хооронд гэрээний хугацаа, нас, хүйсээс хамааран өөр байна.</p> <p>Даатгуулагч сар бүрийн хураамжаа зээлийн эргэн төлөлтийн графиктай уялдуулан тэнцүү хэмжээгээр хуваан төлж болно.</p>					
Даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ	Даатгалын гэрээний зардал нь хамгийн ихдээ 20% байхаар тооцоололд тусгасан.						